



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг:  
boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим  
хаяг:tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Ариунтуяа

Утас:70432545

Цахим хаяг: ariuntuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	2
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	11
3.1 Төлбөрийн акт .....	11
3.2 Албан шаардлага.....	12
3.3 Зөвлөмж .....	13
3.3.1 Байгууллагын даргын гаргаж буй тушаал шийдвэртэй холбоотой асуудал .....	13
3.3.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой асуудал.....	13
3.3.3 Өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудал .....	13
3.3.4 Илүү цагийн нэмэгдэл хөлстэй холбоотой асуудал .....	14
3.3.5 Түрээсийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал.....	14
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	15
5. төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл .....	16

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМД	Эрүүл мэндийн даатгал

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.23 № 113  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

БҮСИЙН ОНОШИЛГОО  
ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ  
Т.БАЯРТОГТОХ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3, 40.3, 40.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.3, 109.5 дахь хэсгүүд болон Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар, 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Төлбөртэй үйлчилгээний төлбөрийн орлогоос 6,400.0 мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн;
- Үр дүнгийн мөнгөн урамшуулал болон цалинг зөрүүтэй тооцож 10,325.6 мянган төгрөг олгосон;
- Шатахууны тооцоо бодоогүй, жолоочийн замын хуудасгүй 8,151.5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй;

842605021

- Ээлжээр ажилладаг ажилчдын илүү цагийн нэмэгдлийг шөнийн цагийн нэмэгдэлтэй давхардуулан олгосон,
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон мөнгөн аяга, морин хуур, бэлэг дурсгалд 11,326.9 мянган төгрөг төсвөөс зарцуулсан;
- Санхүүгийн тайланд өмнөх оны 239,828.0 мянган төгрөгийн өр төлбөрийг үнэн зөв тайлагнаагүй;

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь тайлант онд “Эрүүл мэндийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн ажилтны санаачилгаар 100 бүтээлч ажил”-ыг зохион байгуулсан байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нэг иргэнд ногдох санхүүжилтээр 25,163.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардалд 2,370.7 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

Тайлант онд аймгийн ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 228,0 сая төгрөгийн, төсөл хөтөлбөрийн хандив тусламжаар 50,0 сая төгрөгийн, 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд нийт 200,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд 1 зорилго 8 хөтөлбөр, 64 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хүргүүлсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,126,511,127.33</b>	<b>6,737,877,621.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	34,642,934.03	22,321,200.36
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	34,642,934.03	22,321,200.36
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	34,642,934.03	22,321,200.36
31211	Төрийн сангийн харилцах	34,642,934.03	22,321,200.36
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,521,940,423.39	4,964,465,405.75
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,016,721.00	6,294,384.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,517,923,702.39	4,958,171,021.75
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	21,980,000.00	42,140,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	21,980,000.00	42,140,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,547,947,769.91	1,708,951,015.31
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	944,287,749.12	999,088,593.34
35110	Тусгай зориулалттай материал	475,991,390.23	482,509,026.67
35130	Эм боох материал	468,296,358.89	516,579,566.67
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	603,660,020.79	709,862,421.97
35410	Бичиг хэргийн материал	714,000.00	1,980,000.00
35420	Аж ахуйн материал	11,343,239.95	5,589,127.43
35430	Сэлбэг хэрэгсэл	9,240,650.00	11,201,650.00
35440	Түлш, шатах тослох материал	1,094,720.00	2,311,493.70
35450	Барилгын засварын материал	61,162,025.00	105,145,225.00
35460	Хүнсний материал	2,018,350.00	3,566,890.00
35470	Бусад хангамжийн материал	518,087,035.84	580,068,035.84
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>28,630,540,128.88</b>	<b>26,300,109,794.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	28,630,540,128.88	26,300,109,794.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	27,702,659,023.40	25,396,704,269.83
39201	Барилга, байгууламж, орон сууц	15,465,628,692.34	15,615,614,341.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,707,686,661.70	-3,118,257,092.90
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,284,931,563.10	2,284,931,563.10
39204	Хуримтлагдсан элэгдэл	-773,970,126.20	-988,470,673.25
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,080,421,021.68	23,487,984,309.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-
		10,708,745,477.02	12,924,292,782.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	795,935,002.06	822,580,002.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-338,451,939.14	-432,969,358.67
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,106,837,811.00	1,344,504,551.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-502,507,097.72	-695,366,824.13
39217	Ном	266,235.00	446,235.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	927,881,105.48	903,405,524.34
39301	Програм хангамж	218,805,189.00	221,405,189.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-107,152,083.52	-134,227,664.66
39303	Бусад биет бус хөрөнгө	816,228,000.00	816,228,000.00

<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>31,757,051,256.21</u></b>	<b><u>33,037,987,415.59</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,005,980,418.57</u></b>	<b><u>2,861,376,666.91</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,005,980,418.57	2,861,376,666.91
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,005,980,418.57	2,861,376,666.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	12,313,632.53	145,743,812.50
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,993,666,786.04	2,715,632,854.41
41361	Байгууллагад төлөх өглөг	1,990,273,786.04	2,710,548,354.41
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	3,393,000.00	5,084,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>29,751,070,837.64</u></b>	<b><u>30,176,610,748.68</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	29,751,070,837.64	30,176,610,748.68
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,876,720,589.00	6,876,720,589.00
51101	Өмч: - төрийн	6,876,720,589.00	6,876,720,589.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	15,096,501,165.78	15,522,041,076.82
51210	Өмнөх үеийн үр дүн	15,096,501,165.78	15,072,907,571.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	449,133,505.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	7,777,849,082.86	7,777,849,082.86
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>31,757,051,256.21</u></b>	<b><u>33,037,987,415.59</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>29,265,908,242.75</b>	<b>34,233,536,871.87</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,736,139,090.75</b>	<b>2,112,081,897.87</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,736,139,090.75	2,112,081,897.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,736,139,090.75	2,028,031,897.87
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	930,924,092.16	812,865,471.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,757,842,098.23	1,215,166,426.77
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	00.00	84,050,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>26,529,769,152.00</b>	<b>32,121,454,974.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	15,130,000.00	1,146,621,064.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,130,000.00	177,625,317.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	968,995,747.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,765,839,700.00	2,370,674,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,765,839,700.00	2,370,674,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	24,748,799,452.00	28,604,159,810.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,748,799,452.00	28,604,159,810.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>30,138,735,585.49</b>	<b>33,729,782,722.94</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,138,735,585.49</b>	<b>33,729,782,722.94</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	30,102,149,579.92	32,764,434,425.94
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	16,192,130,269.68	17,338,974,618.51
210101	Үндсэн цалин	6,431,959,098.43	7,679,056,490.65

210102	Нэмэгдэл	8,021,527,942.58	7,836,738,373.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	492,896,749.67	683,376,592.62
210104	Урамшуулал	1,245,746,479.00	1,139,803,161.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,055,623,006.20	2,209,358,896.06
210201	Тэтгэврийн даатгал	1,435,988,531.77	1,394,500,615.73
210202	Тэтгэмжийн даатгал	173,046,466.37	176,837,510.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	100,401,703.00	223,530,884.00
210204	Ажилгүйдлийн даатгал	97,584,526.06	81,456,672.00
210205	Эрүүл мэндийн даатгал	248,601,779.00	333,033,214.33
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	1,711,129,910.43	2,421,485,857.65
210301	Гэрэл, цахилгаан	255,117,105.33	372,330,455.16
210302	Түлш, халаалт	1,038,312,725.10	1,504,471,802.49
210303	Цэвэр, бохир ус	417,700,080.00	544,683,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	291,914,507.55	423,169,673.82
210401	Бичиг хэрэг	63,099,230.00	79,107,365.00
210402	Тээвэр, шатахуун	221,397,830.00	184,030,156.30
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,673,937.55	8,775,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	89,941,582.52
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,743,510.00	61,315,570.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,183,765,938.04	6,271,959,401.11
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,738,212,347.00	5,828,002,511.11
210502	Хоол, хүнс	445,553,591.04	443,956,890.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	507,524,893.51	653,645,119.39
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,400,000.00	26,201,909.91
210604	Урсгал засвар	479,124,893.51	627,443,209.48
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	23,449,400.00	58,607,050.00
210702	Дотоод албан томилолт	23,449,400.00	58,607,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,337,978.90	184,673,091.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	45,198,350.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,459,050.00	18,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500,000.00	7,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	968,215.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,400,000.00	92,636,526.08
210807	Газрын төлбөр	6,905,928.90	19,020,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	1,400,000.00	850,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,095,273,675.61	3,202,560,718.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	24,000,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,095,273,675.61	3,178,560,718.32
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	36,586,005.57	965,348,297.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	36,585,466.00	965,348,297.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	265,173,297.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	685,560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,585,466.00	14,615,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-872,827,342.74</b>	<b>503,754,148.93</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	54,620,643.89
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	54,620,643.89

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-54,620,643.89
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>-872,827,342.74</b>	<b>449,133,505.04</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	(төгрөгөөр)
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,793,037,736.70	21,065,627,577.63	35,735,385,903.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>6,876,720,589.00</b>	<b>7,793,037,736.70</b>	<b>21,080,816,231.47</b>	35,750,574,557.17
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,980,169,310.78	-1,980,169,310.78
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,777,849,082.86	15,096,501,165.78	29,751,070,837.64
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,777,849,082.86	15,096,501,165.78	29,751,070,837.64
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-23,593,594.00	-23,593,594.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>6,876,720,589.00</b>	<b>7,777,849,082.86</b>	<b>15,072,907,571.78</b>	29,727,477,243.64
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,876,720,589.00	7,777,849,082.86	15,522,041,076.82	30,176,610,748.68

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	(Төгрөгөөр)
			Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<b>28,739,997,285.13</b>	<b>29,578,123,125.74</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	978,296,992.52	896,915,471.10
120	Нийтлэг татварын бус орлого	978,296,992.52	896,915,471.10
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	978,296,992.52	812,865,471.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	930,924,092.16	812,865,471.10
120016	Буцаан авсан албан татвар /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>27,761,700,292.61</b>	<b>28,681,207,654.64</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,130,000.00	1,146,621,064.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,130,000.00	177,625,317.00



131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	968,995,747.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,765,839,700.00	2,370,674,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,765,839,700.00	2,370,674,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	25,980,730,592.61	25,163,912,490.64
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,980,730,592.61	25,163,912,490.64
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>28,792,055,911.10</b>	<b>29,590,444,859.41</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,792,055,911.10</b>	<b>29,590,444,859.41</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>28,755,469,905.53</b>	<b>28,625,096,562.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	16,633,603,447.82	17,380,997,497.60
210101	Үндсэн цалин	6,873,432,178.06	7,679,056,490.65
210102	Нэмэгдэл	8,055,468,297.98	7,878,761,252.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	501,801,492.11	683,376,592.62
210104	Урамшуулал	1,202,901,479.67	1,139,803,161.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,724,018,113.77	2,033,762,700.00
210201	Тэтгэврийн даатгал	2,172,635,713.77	1,386,207,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	137,845,600.00	161,888,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	68,922,800.00	80,944,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	68,922,800.00	80,944,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	275,691,200.00	323,777,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,042,480,293.09	2,456,154,000.00
210301	Гэрэл, цахилгаан	280,499,126.71	372,204,455.16
210302	Түлш, халаалт	1,295,828,406.38	1,539,265,944.84
210303	Цэвэр, бохир ус	466,152,760.00	544,683,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	349,024,904.55	295,587,624.00
210401	Бичиг хэрэг	25,000,000.00	63,176,645.00
210402	Тээвэр, шатахуун	182,513,780.00	151,635,979.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,368,834.55	8,775,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	73,614,330.00	40,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	59,527,960.00	32,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,299,984,731.32	5,569,383,162.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,781,724,573.32	5,134,828,972.81
210502	Хоол, хүнс	458,260,158.00	377,122,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	60,000,000.00	57,432,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	641,090,764.98	457,135,463.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	225,208,821.98	44,194,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,084,400.00	1,648,400.00
210604	Урсгал засвар	413,797,543.00	411,292,263.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	23,833,600.00	58,607,050.00
210702	Дотоод албан томилолт	23,833,600.00	58,607,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	41,434,050.00	251,396,565.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	110,058,350.00
210803	Даатгалын үйлчилгээ	10,459,050.00	18,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500,000.00	7,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	968,215.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,500,000.00	90,500,000.00
210807	Газрын төлбөр	00.00	19,020,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,302,000.00	850,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,000,000.00	4,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>24,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	24,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>36,586,005.57</b>	<b>965,348,297.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>36,585,466.00</b>	<b>965,348,297.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	265,173,297.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	685,560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,585,466.00	14,615,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-52,058,625.97</b>	<b>-12,321,733.67</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>98,072,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>98,072,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	98,072,500.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-52,058,625.97</b>	<b>-12,321,733.67</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>86,701,560.00</b>	<b>34,642,934.03</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>34,642,934.03</b>	<b>22,321,200.36</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	28,219,705,634.03	29,590,444,859.41
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	28,219,705,634.03	29,590,444,859.41
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	27,016,428,534.03	28,625,096,562.41
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	16,188,883,700.00	17,380,997,497.60
210101	Үндсэн цалин	7,349,335,300.00	7,679,056,490.65
210102	Нэмэгдэл	6,831,492,300.00	7,878,761,252.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	935,938,200.00	683,376,592.62
210104	Урамшуулал	1,072,117,900.00	1,139,803,161.45
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,023,610,500.00	2,033,762,700.00
210201	Тэтгэврийн даатгал	1,376,055,100.00	1,386,207,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	161,888,900.00	161,888,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	80,944,400.00	80,944,400.00

210204	Ажилгүйдлийн даатгал	80,944,400.00	80,944,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	323,777,700.00	323,777,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,456,154,000.00	2,456,154,000.00
210301	Гэрэл, цахилгаан	372,204,455.16	372,204,455.16
210302	Түлш, халаалт	1,539,265,944.84	1,539,265,944.84
210303	Цэвэр, бохир ус	544,683,600.00	544,683,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	313,437,800.00	295,587,624.00
210401	Бичиг хэрэг	72,662,800.00	63,176,645.00
210402	Тээвэр, шатахуун	150,000,000.00	151,635,979.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,775,000.00	8,775,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,000,000.00	40,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,000,000.00	32,000,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,321,013,800.00	5,569,383,162.81
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,837,581,800.00	5,134,828,972.81
210502	Хоол, хүнс	430,000,000.00	377,122,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	53,432,000.00	57,432,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	586,452,134.03	555,207,963.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	44,194,800.00	44,194,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,111,000.00	1,648,400.00
210604	Урсгал засвар	540,146,334.03	509,364,763.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	39,333,600.00	58,607,050.00
210702	Дотоод албан томилолт	39,333,600.00	58,607,050.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	87,543,000.00	251,396,565.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,673,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	18,500,000.00	18,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	7,500,000.00	7,500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	4,000,000.00	968,215.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,500,000.00	90,500,000.00
210807	Газрын төлбөр	19,020,000.00	19,020,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	2,350,000.00	850,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,000,000.00	4,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1203277100.00	965348297.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,203,277,100.00	965,348,297.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	515,919,700.00	265,173,297.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	651,204,000.00	685,560,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	36,153,400.00	14,615,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	28,219,705,634.03	29,578,123,125.74
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,548,300,300.00	2,370,674,100.00
132001	Орон нутгийн төсвөөс	2,370,674,100.00	2,370,674,100.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	23,431,749,700.00	25,163,912,490.64
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,431,749,700.00	25,163,912,490.64

<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,239,655,634.03	812,865,471.10
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	807,889,000.00	812,865,471.10
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,397,123,700.00	00.00
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	00.00	84,050,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	84,050,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	34,642,934.03
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	22,321,200.36

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 879,078.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 240,561.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа <sup>1</sup> -г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үлдэх өртөгтэй үндсэн хөрөнгийг акталж устгахтай холбоотой үүссэн гарзыг үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар бүртгээгүй
- 100 жилийн ойд зориулан хандиваар төрийн бус байгууллагаас ирүүлсэн 300 хүний гарын бэлгийг бүртгэлд тусгаагүй байсныг үнэ төлбөргүй бараа материалаар бүртгүүлэн залруулсан
- Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг оруулаагүйгээс элэгдэл бодогдоогүй 3 хөрөнгийг залруулан ашиглах жилийг оруулан элэгдлийг нөхөн тайлагнасан
- Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/167 тоот тушаалаар ТЕЗ болон ТТЗ-дын харьяа байгууллагуудад 2025 онд шилжүүлсэн тоног төхөөрөмжийг /Ходоодны дуран/ бүртгэлд тусгасан.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан. Шалгагдагч байгууллагаас тайланд хийсэн залруулгыг хүлээн зөвшөөрч залруулсан санхүүгийн тайланг ирүүлсэн болно.

Залруулагдаагүй 638,517.0 мянган төгрөгийн 10 зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 638,517.0 мянган төгрөгийн 10 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 16,725.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 18,700.0 мянган төгрөгийн 1 алдаа зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх шаардлагатай гэж үзэн МУЕА-т уламжлан, 290,854.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Төлбөрийн акт

**3.1.1** Тайлант онд байгууллагын удирдлага нь санхүүгийн ажилтнуудын ажлыг улирал бүр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон боловч тус урамшуулалтай давхардуулан эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 24

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

өдрийн А/243 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажилласан гэх үндэслэлээр 4,787.8 мянган төгрөгийн урамшуулал илүү олгоод буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн, сахилгын шийтгэл ногдуулсан нэр бүхий 3 албан хаагчдад үр дүнгийн нэмэгдэл олгосон, цалинг зөрүүтэй тооцож урьдчилгаа суутгаагүй, авлага бүртгээгүй 5,537.8 мянган төгрөг нийт 10,325.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

**3.1.2** Тайлант онд өндөр өртөгтэй үйлчилгээний төлбөрийн орлогыг түүвэрлэн хянахад ЭМДҮЗ-н жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 04-р тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан М16, М17, М18 оношны кодтой нэр бүхий 4 иргэний төлбөрийг аваагүй 6,400.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ЭМДҮЗ-н 04-р тогтоолын нэгдүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.5-д бүх орлого, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх гэсэнтэй тус тус нийцээгүй санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

**3.1.3** Аюу Амрида ХХК-ны гүйцэтгэсэн өндөр өртөгтэй үйлчилгээний төлбөрийн орлогыг түүвэрлэн хянахад ЭМДҮЗ-н жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай 04-р тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан S72, W01, W00 оношийн кодоор үйлчилгээ авсан 11 иргэний үйлчилгээний төлбөрийг төр хариуцах нэрээр программд бүртгэн, оношийг зөрүүтэй бичсэн, иргэнээс бэлэн мөнгө авсан байж болзошгүй зөрчил илэрсэн нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, ЭМДҮЗ-н 04-р тогтоолын нэгдүгээр хавсралт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ, 14.4.5-д бүх орлого, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-т уламжлан хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах

## **3.2 АЛБАН ШААРДЛАГА**

### **3.2.1 Нягтлан бодох бүртгэл, хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Байгууллагын санхүүгийн баримтын түүвэрлэн хянахад нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын иж бүрдлийг хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн, төлбөрийн хүсэлт байхгүй, нярвын дансаар дамжуулан зарцуулсан, гүйлгээнүүдийн анхан шатны баримт дутуу тооцоо бодсон акт байхгүй, төсөв төлөвлөгөө, зурагт тайлан байхгүй, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, иргэний өөрөө хариуцах төлбөрийг тасаг нэгж үйлчилгээ бүрээр хянахад кассын мөнгөн орлого зөрүүтэй, шатахууны зарцуулалтыг хянахад тооцоо бодоогүй, алсын дуудлагаас бусад үйл ажиллагаанд зарцуулсан шатахууны тооцоо зөрүүтэй байгаа нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул, төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон мөнгөн аяга, морин хуур, цагаан идээний багц, бэлэг дурсгалыг төсвөөс зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, Монгол улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт заасан заалтуудтай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.3.1 Байгууллагын даргын гаргаж буй тушаал шийдвэртэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Байгууллагын даргын гаргаж буй тушаал шийдвэрийн зүйл заалтыг хянаагүй, ур чадварын тушаалын үндэслэлийг хавтгайруулан тушаал бүр дээр алдаатай байгаа нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.3-т "Захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах" 40.3-т "Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана", 40.4-т Захиргааны актад тухайн захиргааны акт гаргах шаардлага бүхий бодит нөхцөл байдлыг тодорхой заана гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Байгууллагын даргын А,Б тушаалын хууль зүйн үндэслэлийг хуулийн мэргэжилтнээр хянуулан захиргааны актын шаардлагыг хангаж ажиллах.

#### **3.3.2 Худалдан авах ажиллагааны төлөвлөлттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авсан ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хэмжээнээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн, төлөвлөлтийг тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөх Засгийн газрын 1 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар гэсэнтэй нийцэхгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн тооцоог өмнөх онуудын гүйцэтгэлд суурилан оновчтой төлөвлөх, алдаа дутагдлыг давтан гаргахгүй байх

#### **3.3.3 Өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Тайлант онд 2024 оны 4 дүгээр улирлын үр дүн, илүү цагийг тайлант оны санхүүгийн тайланд өр төлбөрөөр бүртгэлгүй он дамжуулан олгосон нь санхүүгийн тайланг үнэн зөв тайлагнаагүй зөрчил илэрсэн энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т " Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т " Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Тайлант оны өр төлбөрийг санхүүгийн жилээр тооцон үнэн зөв бүртгэн, тайлагнах

### **3.3.4 Илүү цагийн нэмэгдэл хөлстэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Ээлжээр ажилладаг ажилчдын илүү цагийн нэмэгдлийг шөнийн цагийн нэмэгдэлтэй давхардуулан олгосон алдаа зөрчил илэрсэн нь Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1, 109.3, 109.5 дахь хэсэг, ЗГ-н 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Илүү цагийн нэмэгдэл, шөнийн цагийн нэмэгдлийг давхардуулан олгохгүй байх

### **3.3.5 Түрээсийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Түрээслэгч байгууллагын ирүүлсэн үнийн саналыг харгалзан үзээгүй, туслах үйл ажиллагааны орлогыг дутуу бүрдүүлсэн нь ажил хариуцсан ажилтны хариуцлагагүй байдлаас орлого тасарсан зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т " Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Түрээслэгчтэй түрээсийн гэрээ хууль тогтоомжийн дагуу байгуулж, өөрийн орлогын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Үндсэн хөрөнгө акталсны гарзыг бүртгээгүй	1	54620.6	1	54620.6			1	54620.6				
Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгө, бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй	1	76024.4	1	76024.4			1	76024.4				
Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөрүүтэй тайлагнасан	2	109,916.6			2	109,916.6	2	109,916.6				
<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>240,561.6</b>	<b>2</b>	<b>130,645.0</b>	<b>2</b>	<b>109,916.6</b>	<b>4</b>	<b>240,561.6</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаагүй	1	290,854.3			1	290,854.28				
Санхүүгийн тайланд өр төлбөрийг үнэн зөв тайлагнаагүй	1	296,840.3					5	296,840.30		
ХАА-ны төсөвт өртгийн дээд хязгаараас давсан худалдан авалт хийсэн	1	-					1	-		
Түрээслэгчтэй гэрээ байгуулаагүй, түрээсийн төлбөрийг дутуу бүрдүүлсэн.	1	4,070.0					1	4,070.00		
Илүү цагийн нэмэгдлийг шөнийн цагийн нэмэгдэлтэй давхацуулан олгосон	1	-					1	-		



Тушаал шийдвэрийн зүйл заалтыг хянах, ур чадварын тушаалын үндэслэлийг хавтгайруулан тушаал бүр дээр үндэслэхгүй байх	1	-					1	-		
Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон мөнгөн аяга, морин хуур, цагаан идээний багц, бэлэг дурсгалыг төсвөөс зарцуулсан	1	11,326.8					1	11,326.80		
Өндөр өртөгтэй үйлчилгээний төлбөрийг төр хариуцах нэрээр программд бүртгэн, иргэнээс бэлэн мөнгө авсан байж болзошгүй	1	18,700.0							1	18,700.00
Балансын урамшуулал, үр дүнгийн нэмэгдлийг давхардуулан олгосон	1	10,325.6	1	10,325.6						
Өндөр өртөгтэй үйлчилгээний төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлсэн	1	6,400.0	1	6,400.0						
	<b>10</b>	<b>638,517.0</b>	<b>2</b>	<b>16,725.60</b>	<b>1</b>	<b>290,854.28</b>	<b>10</b>	<b>312,237.10</b>	<b>1</b>	<b>18,700.0</b>

### 5. төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		